



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 216

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө эзэмшүүлж, бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцаас санхүүжүүлэн барьж ашиглалтад оруулсан нийт 1,251,707,276.00 (нэг тэрбум хоёр зуун тавин нэгэн сая долоон зуун долоон мянга хоёр зуун далан зургаан) төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу Дундговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, Дундговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Г.Хишигдаваа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг тус тус даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, байнгын ашиглалтад хүлээн авч, бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл) т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005472
14-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн
236 дугаар тогтоолын хавсралт



Дундговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын
өмчид бүртгэх үл хөдлөх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Барилгын хүчин чадал	Гүйцэтгэлээрх дүн /төгрөгөөр/	Улсын комиссын актын дугаар
1	Ахмадын өргөөний барилга /Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7-р баг/	2 давхар, зоорьтой, НИЙТ тэнхлэгээрээ 21.0м*12.0м, 15.0м*13.0м	1,251,707,276.00	2022-12-26 УКД-42/2022
	Нийт дүн		1,251,707,276.00 (нэг тэрбум хоёр зуун тавин нэгэн сая долоон зуун долоон мянга хоёр зуун далан зургаан)	